



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/541

Эрдэнэт



Дэмжлэг үзүүлэх тухай



Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1./а/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 13.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 3 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын Ахмадын өдрийг угтан зохион байгуулж буй “Ахмадууд дуулж байна” дуу, бүжгийн цэнгүүний зардалд 710 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 710 000 /Долоон зуун арван мянган/ төгрөгийг “Ахмад настуудын хөдөлмөр бүтээлийг алдаршуулах төрөл бүрийн олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.ТҮВШИНЖАРГАЛ